



МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 108/1410

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 11 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021508040

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 25 дугаар сарын 27 -ны өдрийн
ХЭРГ/АХТД дугаар албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ НАРААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан эсэх, боловсруулсан бол урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилго, зорилтын хэдийг нь ямар хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгасан, оролцогчдоос санал авсан байдал, саналыг тусгасан, тусгаагүй үндэслэл болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх явцын талаар

1.1. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулахад дараахь хуулийн шаардлагыг үндэслэсэн. Үүнд:

○ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээтэй байх¹;

○ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх²;

○ Санхүүжилтийн баталгаат эх үүсвэртэй, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжих төсөл, арга хэмжээний задаргаатай байх³;

○ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах⁴.

1.2. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төсөлд тусгах арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, төслийг боловсруулахад дараахь зарчмыг баримталсан:

○ Төлөвлөгөөний төсөл нь Коронавируст цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагаврыг саармагжуулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн байх;

○ Төлөвлөгөөний төсөл нь макро эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байх;

○ Төлөвлөгөөний төсөл нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тодорхойлсон зорилго, зорилтын хэрэгжилтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн байх.

Түүнчлэн, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх арга

¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.11 дэх заалт

² Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.1 дэх заалт

³ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.2 дахь заалт

⁴ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.5.3 дахь заалт

хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төсөлд тусгахыг зорьж, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн төсөл” болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулсан.

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төсөлд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилт, үйл ажиллагааны 23 хувь, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан зорилго, зорилт, үйл ажиллагааны 48 хувь, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”- туссан зорилго, зорилт, арга хэмжээний 51 хувийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын нийт 1,841 саналыг авч, нэгтгэн судалж, боловсруулсан. Төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналын тоо, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ

Санал ирүүлсэн байгууллага	Ирүүлсэн санал						
	Тоо	Улсын төсөв (тэрбум төгрөг)	Орон нутгийн төсөв (тэрбум төгрөг)	Гадаадын зээл, тусламж (тэрбум төгрөг)	Концесс, төр хувийн хэвшил (тэрбум төгрөг)	Бусад (тэрбум төгрөг)	Нийт (тэрбум төгрөг)
Төрийн захиргааны төв байгууллага	616	5,955.0	37.0	7,514.0	2,085.0	5,497.0	21,090.0
Төрийн захиргааны байгууллага	165	574.0	3.0	163.0	0	7.3	749.0
Нутгийн захиргааны байгууллага	1000	7,528.0	1,121.8	2,572.4	4,059.0	3,941.7	17,998.0
Нийт	1,841	14,058,063	1,163,035	10,250,144	6,144,483	9,446,533	39,837,143

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл”-ийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу (1) Ковид-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг саармагжуулах, (2) макро эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах болон (3) эдийн засгийн эрчимтэй сэргэлтийг дэмжиж, хөгжлийг дунд хугацаанд хязгаарлаж буй хүчин зүйлүүдийг шийдвэрлэхэд чиглүүлэх хүрээнд үр дүн нь гарахаар тооцсон.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т заасан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Асуулга 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд боловсруулсан хуулийн төслүүдийг 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын явцын талаар

“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 4 дүгээрт Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийг

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулахыг Засгийн газарт даалгасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.” гэж заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Төсвийн тухай болон бусад хуулийг нийцүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслүүдийг боловсруулсан.

Түүнчлэн, уг хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны дарга С.Бямбацогтоос 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн УИХ-03/1989 тоот бичгээр ирүүлсэн 5 саналыг судалж, Засгийн газрын 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанд танилцуулан 4 саналыг нь хуулийн төсөлд тусгасан болно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийг нийцүүлэх зорилгоор нийт 53 хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 66 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх хугацааг товлох тухай” 2021 оны 5 сарын 5-ны өдрийн ХЭГ/1228 дугаартай албан бичгийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд хүргүүлээд байна.

Асуулга 3. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт дүн шинжилгээ хийж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хуульд нийцүүлж, шинэчлэн батлах шаардлагатай хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх явцын талаар, одоо үйлчилж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгээс хэдийг нь хүчингүй болгох, хэдийг нь урт хугацааны бодлогод нийцүүлэн нэгтгэн боловсруулж байгаа ажлын явцын талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6, 9.4.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 1.3 дахь хэсэг, 2021 оны 10 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн үндэсний, салбар, салбар дундын болон орон нутгийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх тухай санал, дүгнэлтийг нэгтгэж, боловсруулсан.

Үндэсний, салбарын, салбар дундын болон орон нутгийн хэмжээнд мөрдүүлэхээр баталсан нийт 562 бодлогын баримт бичгийн мэдээллийг бүрдүүлж, түүнд дүн шинжилгээ хийсэн. Тухайлбал,

1. Улсын Их Хурлын тогтоолоор баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт 53 баримт бичиг, Улсын Их Хурлын харъяа байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталсан 2 баримт бичиг байгаагаас хууль зүйн үндэслэл бүхий нийгэм,

эдийн засгийн ач холбогдолтой Улсын Их Хурлаас баталсан 17 бодлогын баримт бичгийг хүчин төгөлдөр хэвээр үлдээхээр, харин Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан баримт бичгийн төрөлд тусгагдаагүй, 9.2-т заасны дагуу Улсын Их Хурлаас батлах баримт бичигт хамаарахгүй, 11 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцээгүй 34 баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгаж, хүчингүй болсонд тооцох талаарх саналыг боловсруулсан бөгөөд “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг ханган ажиллаж байна.

2. Засгийн газар, түүний гишүүн, төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 197 үндэсний, салбарын болон салбар дундын урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн, аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын шийдвэрээр баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 314 бодлого, төлөвлөлтийн баримт бичиг байна. Эдгээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа болно.

Асуулга 4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан холбогдох журмыг 2021 оны 3 дугаар сарын дотор баталж, тайлбарлан таниулах ажлын явцын талаар

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.7, 9.3.8, 9.4.9, 21.4-т тус тус заасан журмыг боловсруулах хүрээнд дараахь журмыг батлаад байна:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.8 болон 21.4-т заасны дагуу Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”;

2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.7-д заасны дагуу Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;

3.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.9, 22.5-д тус тус заасны дагуу Үндэсний хөгжлийн газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А-41 дүгээр тушаалаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн санг эрхлэн хөтлөх журам”.

Асуулга 5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх талаар салбар болон орон нутгийг нэгдсэн удирдлага, арга зүй болон шаардлагатай системчлэл, загварчлал, аргачлал, гарын авлага, программаар хангах ажлын явцын талаар

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг салбар болон бүс орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах хүрээнд дараахь арга хэмжээ авч ажиллаж байна:

5.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх талаар салбар болон орон нутгийг нэгдсэн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах хүрээнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 15.2, 17.2-т заасан чиг үүргийнхээ дагуу Нийслэлийн Засаг дарга, 21 аймгийн Засаг даргаас боловсруулж ирүүлсэн “Аймаг нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 21 төсөл, “Аймаг нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 19 төсөл, нийт 40 хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 12 дугаар сарын 6-ны өдрийн хооронд хянаж, санал дүгнэлтийг ажлын 5 хоногт багтаан бэлтгэн, тухайн нутгийн захиргааны байгууллагад албан тоот болон цахим хэлбэрээр шуурхай хүргүүлэх арга хэмжээг авч ажилласан.

- Санал, дүгнэлт боловсруулахдаа хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэх аргачлал, үнэлгээний загвар маягтыг боловсруулж, уг аргачлалын дагуу хянан үзсэн.

- “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөл, “Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах арга зүйн сургалтыг Завхан, Төв, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад 2020 оны 11, 12 дугаар сард зохион байгуулсан.

5.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардлагатай аргачлал, гарын авлагаар хангах хүрээнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.7-д заасан журмын төслийг боловсруулах хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах аргачлалыг боловсруулсан.

- Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгчдийг нэгдсэн арга зүйгээр хангах, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг олон улсын байгууллагуудтай хамтран боловсруулж, сертификаттай сургалтыг тогтмол зохион байгуулж байна. <https://dpp-mongolia.thinkific.com/>

5.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардлагатай системчлэл, програмаар хангах хүрээнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх систем (<http://www.development.gov.mn>)-ийг гарын авлагын хамт Азийн хөгжлийн банктэй хамтран боловруулж дууссан. Тус системд хөгжлийн бодлогын баримт бичгийг байршуулах туршилт, холбогдох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Мөн орон зайн мэдээллийн систем, тоон шинжилгээний системийг уялдуулж, орон зайд хөгжлийг төлөвлөх, гүйцэтгэлийг удирдах, түүнд хяналт-шинжилгээ хийх систем хөгжүүлэлтийн туршилтын ажлыг гүйцэтгэж байна.

- “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох систем”-ийг орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулахад ашиглаж байна. <http://di.nda.gov.mn/>

- Монгол Улсын онцлогт тохирсон салбарын болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн аргазүйг эрдэмтэдтэй хамтран боловсруулж,

хөгжлийн бодлого төлөвлөгч нарт цахимаар танилцуулан хэвлэмэл хэлбэрээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох мэдээллийг Үндэсний хөгжлийн газрын цахим хуудсанд байршуулаад байна.

Асуулга 6. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах, хариуцсан байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, чиг үүрэг болон тогтолцооны дотоод үйл ажиллагааг хангах хүчин зүйлийг оновчтой тогтоож, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дэд бүтэц хоорондын хамаарал, төр-хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг тодорхойлон төрийн захиргааны төв байгууллага байгуулах талаарх зураглал гарган, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх явцын талаар

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах, хариуцсан байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулах талаар судалгаа хийж, санал боловсруулсан бөгөөд дараахь хүчин зүйлийг анхаарч үзсэн. Үүнд:

1. 2012 онд байгуулагдан ажиллаж байсан Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэг, бүтэц, орон тоог харгалзсан;
2. Гадаадын зарим орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан байгууллагыг судлан үзсэн. Тухайлбал, Орос, Хятад, Япон, Солонгос, Малайз гэх мэт;
3. Засгийн газрын одоогийн бүтэц дэх яамдын орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг жишиг болгосон.

Эдгээрийг судлан үзсэний үндсэн дээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийн төсөөлөл, зураглал гаргасан.

Энэ хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 12 дугаар тушаалаар “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

--oOo--

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 05 сарын 10-ны
өдрийг 52 дугаарт бүртгэв.



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А-41

Улаанбаатар хот



Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.2, 8.4 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.9 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсантай холбогдуулан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх, журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсанаар Үндэсний хөгжлийн газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн "Журам батлах тухай" А-158 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Үндэсний хөгжлийн газрын 2021 оны
04 дүгээр сарын 27-ны өдрийн
1-41 тоот тушаалын хавсралт



ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ НЭГДСЭН САНГ ЭРХЛЭН ХӨТЛӨХ ЖУРАМ

/Шинэчилсэн найруулга/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах /цаашид "Мэдээллийн нэгдсэн сан" гэх/-тай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, тус хуулийн 13.3, 16.3, 17.5 дахь хэсгүүдэд заасан арга хэмжээний төлөвлөгөөг салбараар, бүсээр, орон нутгийн түвшинээр болон урт, дунд, богино хугацаагаар ангилан, энгийн ойлгомжтой, цогц хэлбэрээр олон нийтэд хүргэхэд тус сангийн зорилго, ач холбогдол оршино.

1.3. Мэдээллийн нэгдсэн санд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёог тус тус хэрэглэнэ.

1.4. Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн удирдлага, зохион байгуулалт, журмын хэрэгжилт, хяналтыг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

ХОЁР. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

2.1. Мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:

2.1.1. хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9, 13.3, 16.3, 17.5 дахь хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн мэдээллийн сан;

2.1.2. аж үйлдвэрийн цахим мэдээллийн сан;

2.1.3. судалгаа, шинжилгээний баримт бичгийн сан;

2.1.3.1. "хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-д заасан нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ;

2.1.3.2. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл;

2.1.4. орон нутгийн хөгжлийн индекс;

2.1.5. хөрөнгө оруулалтын төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан;

Бүртгэлийн дугаар	16
ЗАСГИЙН ГАРЫН ӨСӨЛ	
ТӨХИРҮҮЛЭГЧ ДАХЬ САНГАЙН	
ХУУЛБАР ОЛГОСОН	
Хуулбар олгосон өдөр	2021 оны 04 сарын 30 ний өдөр

2 1.6.орон зайн мэдээллийн их өгөгдлийн сан;

2.1.6.1.суурь орон зайн өгөгдөлд суурилсан өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ;

2.1.6.2.хиймэл оюун ухаан, орон зайн өгөгдөлд суурилсан ирээдүйн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

2.1.7.бусад холбогдох мэдээллийн сангууд.

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1.Мэдээллийн нэгдсэн сангийн ангилалт, бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, программчлал, хөгжлийн загвар боловсруулалт, шинэчлэлийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

3.2.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Мэдээллийн нэгдсэн санд байршуулах энэхүү журмын 2.1.1-2.1.7-д заасан мэдээллийг хүлээн авах, солилцох хуваарийг батлах бөгөөд мэдээллийг ирүүлэх хугацаа бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаатай ижил байна.

3.3.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгж Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх мэдээллийн төрөл, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлох бөгөөд мэдээлэл бүрдүүлэгч тус бүрт мэдээллийн санд нэвтрэх эрхийг олгохоос гадна мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулах эсэх талаар зөвшөөрөл олгоно.

3.4.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллага нь Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл бүрдүүлэгч байна.

3.4.1.мэдээлэл бүрдүүлэгч нь мэдээллийн дэд сантай байх бөгөөд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд туссан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаа тус бүрээр оруулах;

3.4.2.мэдээлэл бүрдүүлэгч нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасныг үндэслэн мэдээллийг бүрдүүлнэ;

3.4.3.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгж ирүүлэх мэдээллийн форматыг тодорхойлно.

3.4.4.мэдээлэл бүрдүүлэгч нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн дагуу дээр дурдсан мэдээллийг ирүүлэх үүрэгтэй;

3.4.5.мэдээллийн нэгдсэн санд оруулж байгаа өгөгдөл нь Монгол Улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад мэдээлэл байх бөгөөд тус асуудлыг мэдээлэл бүрдүүлэгч бүрэн хариуцна.

Байгаа өгөгдөл нь Монгол Улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад мэдээлэл байх бөгөөд тус асуудлыг мэдээлэл бүрдүүлэгч бүрэн хариуцна.
ХУУЛЬ
Хуулбар олгосон ажлын гарын үсэг
20 31 оны 01 сарын 30

3.4.6.мэдээлэл бүрдүүлэгч нь боловсруулж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй холбоотой дараах мэдээллийг Мэдээллийн нэгдсэн санд оруулна. Үүнд:

3.4.6.1.боловсруулж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл;

3.4.6.2.бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн хурлын протокол, хэлэлцүүлэгт оролцогчдын бүртгэл, мэдээлэл, өгсөн саналын товъёог;

3.4.6.3.хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгасан төсөл.;

3.4.7.мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь холбогдох эрх зүйн акт, тайлан, дүгнэлт, судалгаа, шинжилгээ, баримтаар баталгаажсан байна.

3.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад Мэдээллийн нэгдсэн сангийн тогтвортой үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэнтэй байна.

3.5.1.тус мэргэжилтний ажил үүргийн хуваарийг түүний ажлын байрны тодорхойлолтод тусгахыг тухайн шатны эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана;

3.5.2.хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, түүнтэй холбогдох тайлан, судалгаа, шинжилгээ, тооцоолол, дүгнэлт, зөвлөмжийг дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлнэ;

3.5.3.тус мэргэжилтний мэдээллийн нэгдсэн сангийн ангилалт, бүрдүүлэлт, ашиглалт, хадгалалт, боловсруулалттай холбоотой чадавхжуулах үүргийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна;

3.6.Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл ирүүлэхдээ тухайн мэдээллийг ирүүлэх эрх бүхий байгууллагыг төлөөлөх албан тушаалтан гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгийг дарж баталгаажуулна. Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл ирүүлсэн байгууллага хариуцна.


3.7.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн хяналт, баталгаажуулалтад процессын алдаа гарвал холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг баримтална.

3.8.Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй зөрсөн тохиолдолд батлагдсан баримт бичгийг эх сурвалж болгоно.

3.9.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг боловсруулах, бүрдүүлэх, мэдээлэл байршуулах, ашиглах, хадгалах, хамгаалах, нууцлал болон мэдээлэл түгээх үйл ажиллагаанд MNS 5140:2011, MNS 5552:2005, MNS ISO 17799:2007, MNS ISO/IEC 27001:2009; MNS ISO/IEC 13335-1:2009 зэрэг холбогдох стандарт шаардлагыг мөрдөн ажиллана.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ,
МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

4.1. Мэдээллийн нэгдсэн санг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны



байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлт, салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор албан ажлын хэрэгцээнд ашиглана.

4.2. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг солилцохдоо хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн мэдээлэл солилцооны систем болон цаасан хэлбэрээр дамжуулах ба заавал бүртгэл хөтөлнө.

4.3. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд ашиглах талаар холбогдох этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хуулиудад хориглосноос бусад мэдээллийг ашиглуулах эсэхийг эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

4.4. Мэдээллийн нэгдсэн сан нь төрийн мэдээлэл солилцооны системтэй олон нийтийн оролцоог хангах, ил тод байдлыг хангах, олон нийтэд сурталчлах талаар иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн үндсэн дээр цахим хэлбэрээр холбогдож ажиллана.

4.5. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Мэдээллийн нэгдсэн сан хариуцсан албан хаагч нь жил бүрийн эцэст тухайн жилийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, мэдээлэл солилцооны талаарх мэдээллийг дээд шатны албан тушаалтанд танилцуулна.

4.6. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл солилцооны системд холбогдох техникийн нөхцөл, ажиллах орчны стандартын шаардлагыг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.7. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зорилгоор солилцохыг хориглоно.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ЭРХ ОЛГОХ

5.1. Энэхүү журамд заасан этгээд Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хүсэлтийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр гаргана.

5.2. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах хүсэлт нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан мэдээлэл ашиглах гэрээг энэ журмын 3.3-д заасан нэгж байгуулна.

5.3. Энэ журмын 5.2-д заасан гэрээнд дараах асуудлыг тусгана:

5.3.1. мэдээллийн үйлчилгээний хүрээ;

5.3.2. мэдээллийн үйлчилгээний нэр, төрөл;

5.3.3. ашиглалтын зориулалт;

5.3.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлага;

5.3.5. мэдээллийн нэгдсэн сан, системийн аюулгүй байдал, тогтвортой ажиллагааны нөхцөл

5.3.6. мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх албан тушаал, овог нэр, нэвтрэх нэр, нууц үг;

Видеопалатин үйлчилгээний шаардлагын газрын эрхийлэгчийн газар ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР	16
ХУУЛЬЧ ЭН	
Хуульч эрх зүйн газрын үсэг	
2011 оны 04 сарын 10	